

Авлигатай тэмцэх газраас зарласан “МИНИЙ САНАЛ: АВЛИГАГҮЙ МОНГОЛ” (АСУУДАЛ, ШИЙДЭЛ) сэдэвт эсээ бичлэгийн уралдааны III байрын бүтээл

МУИС-ийн ХЗС-ийн Эрх зүй 1-р дамжааны оюутан Мөнхсайханы ТАМИР

“Миний санал: Авлигагүй Монгол” (асуудал, шийдэл)

“Авлигатай орны ард түмний амьдрал дээшилдэггүй” хэмээсэн үг байдаг. Үнэн юм чинь... Харин энэ дээшилдэггүй нэрэн дор авлига гээчид огтоос хамаагүй иргэд л хамрагдах авай.

Бага байхад л чихний булан тохойгоор авлига гэсэн үг дуулдсаар байдаг байлаа. Тухайн үедээ ч учирийг нь сүрхий ухаж ойлгосонгүй. Яваандаа бодохнээ буруу үйлийнхээ хойноос багшид битгий хэлээрэй гээд ангийнхаа охиныг чихрээр хахуульдаж байсан минь өөрөө авлигын бяцхан хэлбэр байж. Тэр ч байтугай улсаас бидэнд их орны хишиг хэмээн хүртээдэг байсан сар бүрийн 21000 төгрөг хүртэл авлига гээд боддоо. Их орны хишгийг хүртсэн хүн бүр, хүүхэд бүр авлига авчихсан юм чинь яах юм!!! Сүүлд түүнийгээ ойлгов уу гэлтэй Оюу толгой, Таван толгой гэх мэт үндэсний баялаг болсон газар шороогоо хамгаалъя гэвч нэгэнтээ хөдөлчихсөн галт тэргийг гаднаас нь зогсоох аргагүй байж. Том дарга нар өнгөн дээрээ биднийгээ хахуульдаж хуурах аядан амыг минь таглаад ардуураа авахаа аваад, зарахаа зарах их үйлсээ хийчихсэн хэрэг л дээ.

“Ардчилсан төөрөгдөл”...

Ардчилалын давалгааг даган сэлсэн Монгол орон хорь гаруйхан жилийн дотор жинхэнэ “капиталист” нийгмийн хойноос үхэн хатлаа. Мөн чанартаа бол түүнийгээ гүйцэт таньсан зүйлгүй. Марксизмын онолоор бол капитализмыг эдийн засгийн мөлжлөг дээр тогтдог гэдэг. Худлаа ч биш л дээ. Хуучин нийгмийг санагалзсан өвгөд, хөгшид үй олноороо халаглацгаана. Тэдний ихэнхи нь нийгмийн доод давхаргад ардчилалтай хамт хөл алдчихсан. Алдахгүй гээд ч яах билээ. Шударга үнэнийг уландаа гишгэлж, шударга нэгэн нь унадаг үе юм байна. Үнэн гэвэл хориодхон жилийн турш ардчилал нэрэн дор дээр, дооргүй л амьдын эрх, эрх чөлөөгөө ханатлаа эдэлцгээлээ. Үгүй мөн цаддаггүй улс аа. Гайхалтай нь авлига аваарай, хахууль өгөөрэй гэсэн эрх, үүргийг үндсэн хуульд заагаагүй

ч ардчиллын цаад мөн чанарт тусгаад өгчихөө юу гэлтэй. Хачин юм аа. Нэг бодлын байх ёстой зүйл шиг л болж. Хэдий тийм ч авлига байлаа гээд нийгмийн амьдрал доошилно уу гэхээс дээшлэхгүй нь лавтай. Дийлэнх хүний сэтгэхүй би л болж байвал бусад нь хамаагүй гэх хандлагатай.

Социализмын үед мөнөөх чинь авсаархан зүйл дээр хоргүйхэн өрнөнө үү гэхээс ард түмний амьдралд гамшиг тариагүй. Огтоос байхгүй байсан гэвэл хэтийдсэн хэрэг болох буй заа. Ардчилсан нийгмийн дараагаар ашиг сонирхолоо илчилсэн нөхдүүдийн эрх мэдлээ урвуулан ашиглах зэвсэг нь авлига болсон хэрэг. Хаана хамгийн их байдаг нь угтаа тодорхой. Төрийн албанд тодруулбал том, жижиг эрх мэдэлтэний үзэгний үзүүрт, хэтэвчний завсарт. Төрийн албан тушаалтан цалингаараа баяжлаа гэж би хувьдаа дуулаагүй. Хүний хэрэгцээ гэдэг хязгааргүй л дээ. Хязгааргүй хэрэгцээндээ үл ханахыг шунал гэнэ. Харин тэр шуналаас л ард түмнийг мөлжсөн авлигын сэдэл үүссэн биз. Магадгүй өнөөдрийн энэ хямрал, гуйланчлал нь үүний уршиг болой. Магадгүй гэдэг үг ч илүүдсэн байж мэднэ. Цаана нь иргэдийн хөрөнгө урсаж байдаг болохоор тэр.

Би бээр ардчилсан нийгэмд хамаг бурууг тохих гэсэнгүй. Анхнаасаа ардчилалыг байгуулахдаа туршлага дутсан биз. Шилжилтийн үе нь дуусах биш нилээдгүй сунжрах янзтай. Магадгүй энэ янзаараа удаан байвал “ардчилал”-д ялагдахыг үгүйсгэхгүй. Авлига газар авсан хамгийн том шалтгаан нь либерализмын мөн чанарыг таниагүй ард түмэн бидэнд бий. Ард түмэн гэх уг нэрэн дор ашиг сонирхолоо албандаа хутгагсад болоод ардчилал, хуулийн цоорхойг аймшиггүйгээр ашиглан баяжигсад ч бас өөрсдөө хамаатайг санах хэрэгтэй. Эдийн засгийн шинжлэх ухаанд хязгааргүй хэрэгцээгээ хязгаарлагдмал нөөцөөр хангахыг хүний хэрэглээ гэнэ. Уг хязгаарлагдмал нөөцөөс сонгох хэрэглээгээ харин тархиа ашиглаж, хөлсөө урсгаж ариун цагаан хөдөлмөрөөрөө бүтээх нь ардчилалын мөн чанар аж. Хэн илүү хөдөлмөрлөж илүү сэргэлэнтэнэ тэр хүн эдийн засгийн капитал эрх чөлөөг хүртэх эрхтэй ба нийгмийн баялаг хувийн өмч дээр тогтдог гэж капиталист эдийн засгийн онолд номлодог. Амьдрал дээр харин нийгмийн ялгарал үүсгэх хандлагатай. Үүнээс л “зөв, буруу” гэсэн хоёр талт асуудал хөндөгдөнө. Хувийн өмчөө хуулийн дагуу бүтээх эсвэл хууль бусаар олж авах. Мэдээж буруу нь тодруулбал хууль бус мөнгөний урсгал нь авлига болой. Энэхүү ойлголт дотроо хээл хахууль авах, өгөх, зуучлах, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашиглах, төсвийн хөрөнгийг

зориулалтын бусаар ашиглах, ашиг сонирхлоо төрийн албанд хутгах гэх мэт хүнд сурталын олон талт хэлбэр багтана.

Хэн нэгэн төрийн албан хаагчийн хүнд сурталын цаад хүсэл нь мөнгө. Мөнгө өгч байж л ажлаа хурдан амжуулахгүй бол дээд, доод аль нэг шатанд тойгуулдаад гацаагаад байх хандлагатай. Хуулийн дагуу томоохон ажлаа санааны зоргоор бүтээе гэвэл жинхэнэ гонж. Цаана нь өөр нэгэн бизнесийн өрсөлдөгч нь ч юмуу тухайн ажлыг хууль бусаар байсан ч хамаагүй хахууль өгөөд бүтээчихсэн байна. Мөнөөх зах зээлийн эдийн засаг чинь өрсөлдөөн дээр тогтоно. Зах зээлийн өрсөлдөөнд бол хууль байхын хэрэг байхгүй болчихсон. Хэн мөнгөтэй, авлига өгөх чадалтай нь ялагч. Бас л “шударга, шударга бус” –аар өрнөдөг болохоор мөнгө л бүхнийг шийдэх авай. Авлигыг дагаад мөн инфляци өснө. Жишээ нь: Хэн нэгэн компаний захирал зах зээлд борлуулалт явуулахдаа татвар гэх мэт үнийн өсөлтөд хамаатай зүйлс дээрээ нэмээд авлигад өгсөн мөнгөө нөхөх, ашигаа гаргах гээд монополь эрхээрээ таваарын үнийг санаан зоргоор өсгөчихнө. Авлига нь хэдэн тэрбумаар ч яригдаж болох далд мөнгөний урсгал учраас энэ мөнгө нь иргэдэд ямар ч хүртээлгүй. Ард түмэн үүний золиосонд гуйланчлалд автсаар л. Мөнгөтэй нь л ялдаг хорвоо гэлтэй. Угтаа энэ бүхний гол буруу нь шударга ёсыг уллагсдад буй нь тодорхой. Хуулийн дагуу үнэн мөнөөр ажлаа хийгээд авлига авдаггүй бол юутай сайхан бэ? Авах хүн байхгүй бол өгөх гээд байгаа нөхдүүд яаж ч чадахгүй хуулиа дагахаас өөр аргагүй. Гэтэл энэ бүхэн хөөрхийлөлтэй хүмүүний шунал, улаан нүдэлсэн мөнгөний боолчлолын үр. Үнэний дэнс гэж үнэхээр байдаг бол нэг талд нь хууль, нөгөө талд нь ахиухан мөнгө тавьчихад мөнгөтэй тал нь доошлох нь өнөө цагийн үнэн болчихож ээ та минь. Ийм байхад хууль үнэгүйдэх нь мэдээж. Авлигад урсах мөнгө эрх мэдэлтэн болоод баячуудын дансан дахь цифрийг ихэсгэнэ үү гэхээс улс орны хөгжилд нэмэр болохгүй. Нэрмээс л болно.

“Үнэн, худал тэмцэлийн тойрог”...

Авлигагүй орон гэж дэлхийд үгүй л дээ. Харин улс орны нийгэм дэх авлигын их, багыг хэмжих нь төсөөлснөөс ч амархан юмсанж. 2014 оны байдлаар дэлхийн 187 орон хамрагдсан “хүний хөгжилийн индекс”-ийн судалгаагаар манай орон 107 дугаар байранд удаалсан ба эдийн засгийн үзүүлэлт тааруухан, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг нь буурай улсын түвшинд. Гэтэл Улаанбаатарт өнөөдөр өндөр байшингууд сүндэрлээд л, дэлхийн хэрэглээний брэндүүд олширсоор л. Яг л ядруу орны

“мэтро хот”. Гэтэл ард түмний хэдэн хувь нь тухайн өндөр өртөгтэй брэнд, дэлхийн трэндийг өдөр тутмын хэрэглээндээ нэвтрүүлж чадах вэ? Хэд нь чадаж байна вэ? Хариулт нь тодорхой биз ээ. Энэ бол эдийн засгийн үзүүлэлтэд нөлөө үзүүлдэггүй далд мөнгөний урсгал нийгэмд асар их буйн хамгийн энгийн илрэл. Мань мэтийг бага байхад, тодруулбал 2002 онд Монгол улс авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, 2005 онд авлигатай тэмцэх тухай НҮБ-н конвенцид нэгдэн 2006 онд “Авлигын эсрэг хууль”-тай болж “Авлигатай тэмцэх газар” үүдээ нээсэн юм билээ. Гайхалтай нь гэвэл их хуралд суудалтай авлигачид өөрсдөө авлигын хуулийг баталсан гээд бодохоор хэр зэрэг үр өгөөжтэй нь тодорхой биз ээ. Үүнд Авлигатай тэмцэх газрын буруу байхгүй. Тэд хуулийнхаа дагуу л ажлаа хийнэ. Харин буруу нь гэвэл хууль баталдаг түшээд, төрөөс төрсөн тэрбумтнуудад буй. Тэд мэдээж өөрсдийгөө барьж өгөх хүнд зэвсэг болсон хууль гаргахгүй нь ойлгомжтой асуудал. Дургүй хүргэсэн нэгнээ барьж өгдөг хууль л гэлтэй. Цаасан дээр бичсэн тунхаг бодитоор төдийлөн хүчгүй. “Transparency international” олон улсын ашгийн бус байгууллагын судалгаагаар Монгол улс дэлхийн “топ -10” нь авлигатай орны “хоёр”-т жагссан нь авлигын эсрэг тэмцэл үр нөлөөгүй, өгөөжгүй байгаагийн хамгийн том жишээ. Эрх баригчид өнгөн дээрээ авлига буурч байгаа, хууль хэрэгжиж байгаа гэдэг ч үнэндээ байдал улам дордсоныг муугаараа дэлхийд тэргүүлсэн уг судалгаа гэрчилнэ. Нөгөөх л худал хуурмагаа далдалсан тулга тойрсон явуургүй үйлдлүүдийн нэг гэж бодоход хүргэнэ. Авлига гэдэг эрүүгийн онц ноцтой гэмт хэрэг. Өгсөн авсан хоёр нь л мэддэг энэ хэрэгт хамгийн сонин нь “хохирогч” гэж байдаггүй. Тийм ч учраас “Авлигыг илрүүлнэ гэдэг өвсөн дундаас зүү хайхтай адил”.

Авлигагүй Монгол ба “Mongolian Dream”...

Тэгээд авлигатай чухам яаж тэмцэх ёстой вэ? гэсэн үндсэн асуудалтайгаа нүүр тулъя. Дан ганц би биш үүнийг унших та ч бас үүнд хамаатай. Монголчууд өнөөдөр үеийн үед хийсээр ирсэн тулга тойрсон хэрүүлээсээ юуг ч олж долоохгүй. Юуг ч шүү! Тэр дундаа шударга ёсыг амны пангаар олно гэвэл үлгэрийн далай болоод түүндээ живсээр дуусах авай. Хамгийн том асуудал нь гэвэл Монгол хүмүүний сэтгэлгээ. Монголчууд бид цуглаад суухаараа эх орны хөгжилд юу хэрэгтэй тухай эцэс төгсгөлгүй маргачихаад эндээсээ олигтой шийдэл үл олдог. Оллоо ч хэрэгжих шатандаа гацчихдаг эсвэл замаасаа хазайчихна. Эх орны хөгжлийн асуудал нь эдгээр хүнд суртал, авлигатай салшгүй холбоотой. Үүнийгээ цэвэрлээгүй байж хөгжил гэж ярихын ч хэрэг

байхгүй. Хүн нэг бүр сэтгэлгээндээ цоожлогдчихоод ашиг сонирголоо хамгаалан тал тал тийш хөлөө жийцгээх учраас ийм ерөнхий асуудалд яг тийм гэсэн тодорхой хариулт ч олдохгүй. “Хувь хүний хөгжлийн асуудал хорт авлигын нэгэн үндэс гэвэл та итгэх үү?” Хүний хөгжил гэхээрээ боловсрол, эрүүл мэнд гээд явж өгнө дөө. Хэн хүнгүй л гадарлана. Саяхан 97% бичиг үсэг тайлагдсандаа тайвширчихна. Социалист нийгмийн үед энэ бүхэн ихээхэн үр шимийг олж дэлхийд данслагдаж байж. Сайхан юм аа. Гэтэл тухайн үед нэг үзэл суртал марксизмын онолоор өдөр шөнөгүй бөмбөгдүүлж байсан улс чинь гэнэт ардчиллын шуурганд хийсэхдээ тухайн шинэ нийгмийн хөгжилд чухам юу хэрэгтэйг сэхээрч амжаагүй юмсанж. Боловсрол гэдэг улс орны хөгжилд хамгийн хэрэгтэй институтуудын нэг. Хэн ч маргахгүй биз. Харин боловсрол нь хоёр талтай асуудал юм. Бидний ойлгодог боловсрол бол бичиг үсэг, математик, мэргэжил гэх мэт наана ил байдаг зүйлс. Ганц эдгээр баримжаагаар боловсрол гээчийг ойлгоно гэдэг өрөөсгөл. Нөгөө тал нь харин хувь хүний ухамсар, төлөвшилийн асуудал. Социалист нийгмийн үед боловсролын нөгөө талыг мартаагүй харин ч ихээр анхаарч байсан бололтой. “Монгол боловсрол” өнөө цагт мордохын хазгай гэдэг шиг нэг талруу нь хэт анхаарчихаад ухамсар, ёс суртахууны түвшинг ор тас гээчихсэн харагддаг. 1999 онд Нобелийн шагнал хүртсэн Амартъя Сэм хэмээх эдийн засагч Зүүн Азийн шинээр хөгжсөн орнуудыг судлаад, тэдгээр улсын хөгжлийг түргэтгэсэн хамгийн гол хүчин зүйл нь “хүний хөгжил” байсан гэж дүгнэжээ. Гэтэл хүний хөгжилдөө анхаарахгүй улс чинь хөгжих биш уруугаа хардаг юм байна. Огтоос анхаараагүй ч биш л дээ. Хамгийн чухал зүйлийг манай улс орхигдуулсан. Энэ бол хүмүүсийн “ёс суртахуун”. Үүнд хувь хүний үнэлэмж, үзэл баримтлал, итгэл үнэмшил, үйл ажиллагаа, шударга ёс зэрэг надад болон танд хамгийн их байх ёстой хүн чанарын асуудлууд багтдаг. Үүнийг унших та, би, бид бүхэн өөрсдөө олоод авах боломжтой. Эдгээр үнэт зүйлсийг олж аваагүй хүн нийгмийн амьдралд оролцохдоо яах нь тодорхой. Шударга ёс гэдгийг ч угтаа ойлгоогүй хүмүүс үй олноороо. Тэдний дунд ямар ч хамаагүй аргаар мөнгө олоод амьдралаа дээшлүүлэхийг шударга ёс хэмээн ойлгогсод ч хэмжээлшгүй их. “Хууль зөрчсөн хүн сайхан амьдарч, хахууль өгч авалцсан хүмүүс хожиж байхад би бас ингэх нь зөв биз дээ гэж ярьдаг болж, ийм соёл иргэншил дунд залуу үе өсөж торниж байна”... гэсэн багахан ишлэлийг “Өөрийгөө хөгжүүлье” номын өгүүллээс иш татлаа. Дээр дурдсан зүйлс бол Монголд тулгамдсан хамгийн том эмгэнэл. Сэтгэлгээний их гаслан. Ёс

суртахуундаа анхаардаггүй өнгөн хэсэг хувцас хунар, идэх уухаа л мэддэг хүмүүсийн шудрага ёс бол авлигын цаад мөн чанарыг мэдсээр байж өөрсдөө үйлдэх хоосон сэтгэлгээ. Энэ сэтгэлгээг л эхнээс нь өөрчилж чадваас авлига гэдэг оргүй болдоггүй юмаа гэхэд ирээдүйд хэчнээн бага болох бол... Ёс суртахуунтай, шударга ёсыг сахигч иргэд хэдий чинээ их байна авлига төдий чинээ буурна. Хөрсөнд бэхжсэн хогийн ургамлыг үндэсээр нь таслахгүй бол дахин төлжсөөр л байдаг. Харин үүний үндэсийг таслах арга бол ард түмэн бид хувь идиалог “би” буюу өөрийн үнэт зүйлс сэтгэлгээндээ анхаарах, улс орон болбоос залуу үеийнхээ замыг гэрэлтүүлэх болой...

Ядаж л авлигын хэргийг хохирогчтой болговол ямар вэ? Үгүй бол хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхолын мэдүүлэг, хэн нэгний худал, үнэн нь үл мэдэгдэх чулуу хөөлгөсөн мэдээлэл, матаасаас өөр илрүүлэх арга мөхөс байна шүү дээ. Цагдаа сэргийлэх, шүүх засаглал нь хүртэл хүнд суртал, хээл хахуульд идэгдсэн хачин нийгэмд хачин зүйлс далдуур өрнөнө. Угаас энэ авлигын хэрэг чинь нууцаар үйлдэгдэнэ. Нууц юмыг чинь тэгдэг ингэдэг гэж хардахаас өөрөөр цаад үйл явдлын гүнийг нь мэдэх арга үгүй. Хохирогчгүй хэргийг илрүүлнэ гэдэг асар их авъяас билиг. Энэ далдыг харах билгийн ажлын үр өгөөж нь ямар буй нь мөнөөх судалгаанаас тодорхой л доо. Ядаж л уг хэрэгт хохирогч нэмэгдчихвэл авлигын илрэлд хэд дахин ахиц гарах болой. Авлига авч буй нэг нь хохирохгүй нь тодорхой. Ихэнхи тохиолдолд хахууль өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэгсэд чинь тэд. Харин авлига өгчихсөн нөгөө нөхдүүд чинь эд хөрөнгөөрөө хохироод байгаа юм биш үү? Нийгэмд гарч буй авлигын гэмт хэргийн 50% нь хуулийн дагуу хэргээ бүтээх гэсэн боловч авлига өгөхгүй л бол хэн нэгэн албан тушаалтан саад хийдэг гэж бодоход тэднийг авлига өгсөнийх нь дараа хохирогчоор татна гэвэл авлигын түвшин 50% буурна гэсэн үг биз дээ. Монгол орны хууль өнөөдөр, тогооны ёроолын тос шиг л байна. Шүүх засаглалын хараат бус байдал асар ихээр алдагдсаныг хамгаалах хэрэгтэй. Үгүй бол хуулийн үнэ цэн алдагдсаар хууль байх хэрэг үгүй боллоо. Шүүх байгууллагын дунд нүдэнд өртөж, чих дэлсэхгүй том жижиг авлигын хэрэг гардаг бололтойдог. Авлига бүү ав гэж шүүгчийн цалинг нэмсэн нь нөгөө талаас Ерөнхийлөгчийн хуулийн байгууллагад нөлөөгөө тогтоох оролдлого гэмээр. Цагдаагийн албан хаагчид нь хүртэл ард түмнээс бууны нохой гэсэн үгээр ядруу цээрлэл хүртэнэ. Иргэд өөрсдөө ч эрх зүйн мэдлэг таарууханаас улбаалаад хуулинд боолчлогдох аядана. Хог юмаа... Харин өнөөдөр хамгийн эмзэглэнгүй

хэрэгждэггүй асуудал болох “Авлигагүй монгол”-ын талаар ярихаас илүүтэй үүнийг хүн бүрийн сэтгэлд шингээж “Монгол мөрөөдөл” болгох хэрэгтэй. Хүн чанар, ёс зүйн асуудлуудыг залуусын тархинд гүн суулгахыг зорилгоо болгоё л доо. Өнөө цагийн “Mongolian dream” бодитоор хэрэгжвэл ирээдүй бидэн рүү их буугаар буудахгүй нь лавтай.

Ер нь тэгээд авлигыг бууруулах хамгийн чухал асуудал нь дээр дурдсан хүмүүний сэтгэлгээ! Материаллаг баялаг биш мэдлэг боловсрол, ёс суртахуунаар гоёсон хүмүүст мөнгө төдийлөн сонин биш шүү дээ. Өнөө цагт нийгэмд их тэсрэлт, шинэ хувьсгал гарч төрөөс төрсөн тэрбумтнуудыг цээрлүүлэх гэнэтийн үйл явдал болдоггүй л юм бол авлига буурах нь бүү хэл нийгмийн оюун санаа гүн намгаас гарахгүй нь лав. Харин уг оюун санааг татаж гаргах их үйл нь залуу үеийнхээ боловсролд анхаарах тэр дундаа оюун санааных нь төлөвшилд анхаарах шүү дээ. Ядаж л өнөө маргаашдаа бүтдэггүй юмаа гэхэд ирээдүйд хамгийн боломжтой зүйл. Залуус бид өөрсдөө ч бас шударга ёсыг дээдлэгч хүмүүнлэг иргэн болон төлөвшихийг зорих нь чухал. Сайн, муу нь хослон байдаг хорвоод үйлийн үрээс өөр өөдтэй тайлбар олдохгүй юм... Эрхэм хүндэт ухаалаг авлигачид аа!!! Та бүхэн мөнгөө авсандаа чирээд хэвтэхгүйгээс хойш нэгийг бодож, хоёрыг тунгаамаар байна. Юм бүхэнд хэмжээ хязгаар бий шүү дээ. Бүгдээрээ муухар сэтгэлгээрүүгээ бууныхаа амыг чиглүүлбэл боломжгүй зүйл үгүй...

Эцэст нь ухаалаг Монголын “Монгол мөрөөдөл” бидэнд хэрэгтэй.

Хөххангай овогт Мөнхсайханы Тамир

2015 оны 11 сарын 26 нд “Тусгаар тогтнол”-ын өдөр бичиж дуусгав.

Ашигласан материал, эх сурвалж: “Өөрийгөө хөгжүүлье” /2003/

“TRANSPARENCY INTERNATIONAL” байгууллагын судалгаа

2014 оны НҮБ-н “ХХИ-н судалгаа”